



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/11

Мөндөлгөө

"Эерэг өөрчлөлт- Эмэгтэйчүүдийн оролцоо"
уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, 19 дүгээр зүйлийн 19.1.7, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын "Аргачлал, зардлын норматив батлах тухай" А/23, 27 тоот хамтарсан тушаалын 4 дүгээр зүйлийн 4.3, Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын 3-р хавсралт, Төсвийн төвлөрүүлэн захирагчаас Төсвийн шууд захирагчтай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, эмэгтэйчүүдэд итгэл найдвар өгөх, тэдэнд тэгш боломж олгох, зөрчигдөж буй эрхийг нь хамгаалах, охид эмэгтэйчүүд рүү чиглэсэн хүчирхийллийг таслан зогсоох, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Эерэг өөрчлөлт-Эмэгтэйчүүдийн оролцоо" уулзалт хэлэлцүүлгийг 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр зохион байгуулсугай.

2. "Эерэг өөрчлөлт-Эмэгтэйчүүдийн оролцоо" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үйл ажиллагаанд шаардагдах 1,072,350 (Нэг сая далан хоёр мянга гурван зуун тавь) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд үүрэг болгосугай.болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Бүжинлхам), гишүүдэд даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ

№ 482201021

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн
№111 тоот тушаалын 01 дүгээр хавсралт

"ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ-ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО"
УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Бүжинлхам

(Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Гишүүд:

Х.Төмөрбат

(Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн)

Л.Цэвэлмаа

(Нярав)

----oOo----

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны 03 дүгээр сарын 07-ны өдрийн
А.Н. тоот тушаалын 08 дугаар хавсралт

**“ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ-ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО”
УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ**

Зорилго: Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан, эмэгтэйчүүдэд итгэл найдвар өгөх, тэдэнд тэгш боломж олгох, зөрчигдөж буй эрхийг нь хамгаалах, охид эмэгтэйчүүдрүү чиглэсэн хүчирхийллийг таслан зогсоох, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд оршино.

Ерөнхий зохион байгуулагч:

- Аймгийн Засаг даргын Тамгын газар

Хамтран зохион байгуулагч:

- Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
- Монголын эмэгтэйчүүдийн холбооны Дундговь аймаг дах салбар

Хугацаа: 2022 оны 03 дугаар сарын 07-ны 15:00 цагт

Зохион байгуулагдах газар: Төв халхын дуулалт жүжгийн театр

Зөвлөгөөнд оролцогч нар:

- Сайнцагаан сумын 230 эмэгтэйчүүдийн төлөөлөл оролцоно.

ХӨТӨЛБӨР

Хугацаа	Сэдэв	Чиглүүлэгч
14:30-15:00	Оролцогчдын бүртгэл	ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд
15:00-15:10	Нээлтийн үйл ажиллагаа	Дундговь аймгийн засаг дарга, Ц.Мөнхбат Аймгийн ИТХ-ын дарга, С.Од-Эрдэнэ Аймгийн Эмэгтэйчүүдийн холбооны дэд тэргүүн Ж.Өлзийжаргал
15:10-15:20	“Эмэгтэйчүүдийн талаарх төрийн бодлого”	Монголын эмэгтэйчүүдийн холбооны Дундговь аймаг дах салбарын тэргүүлэгч Ж.Өлзийжаргал
15:20-15:40	“Эмэгтэйчүүдийн нийгмийн харилцааны өнөөгийн байдал”	Дундговь аймгийн Тамгын газрын дарга Л.Доржбат
15:40-17:40	“Хувь хүний хөгжил” сэдэвт сургалт	Төгөлдөршил хувь хүний хөгжлийн төвийн захирал Б.Ууганцэцэг
17:40-18:00	Хэлэлцүүлэг /Зөвлөгөөний гарах зөвлөмжид санал авах/	Гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Бүжинлхам
18:00-18:10	Хаалтын үйл ажиллагаа	Зохион байгуулагчид

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2022 оны ᠘᠗ дүгээр сарын ᠗-ны өдрийн
Р/Х. тоот тушаалын ᠘᠗ дугаар хавсралт

“ЭЕРЭГ ӨӨРЧЛӨЛТ-ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦОО”
УУЛЗАЛТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын ангилал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Цэвэр ус	ш	750	223	167,250
2	Печень	ш	1200	223	267,600
3	Мандатны уут	ш	1800	223	401,400
4	Мандат хэвлэл	ш	700	223	156,100
5	Сургагч багшийн хөлс	цаг	40,000	2	80,000
Нийт					1,072,350

—oOo—